



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 11 дугаар  
сарын 18 өдөр

Дугаар 6-АНА


Улаанбаатар  
хот

## Хүүхдийн цэцэрлэг байгуулах тухай

1. Монгол улсын Боловсролын хуулийн 4 дүгээр бүлгийн 27 дугаар зүйлийн 3, 5 дугаар заалт, 3 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг 1999 оны 10 дугаар сарын 29-нөөс эхлэн нээн ажиллуулж, сургалт явуулах тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Шинээр байгуулагдаж байгаа цэцэрлэгийг улсын бүртгэлд бүртгэж, "Нийслэлийн 38 дугаар цэцэрлэг" гэсэн нэр, дугаар өгч гэрчилгээ олгон үйл ажиллагаанд нь зохих хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын дарга Л.Дорж/-д даалгасугай.

3. Тус цэцэрлэгийн орон тоо, төсөв санхүү, материаллаг баазаар хангахад зориулагдсан хөрөнгийг 2000 оны төсөвт тусган шийдвэрлэж өгөхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн хэлтсийн дарга /Д.Гонгор/, Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга /П.Ганбаатар/-нарт даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД  
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД